

2012.06.23



МОНГОЛЫН ГЕОДЕЗИ, ФОТОГРАММЕТР, ЗУРАГ ЗҮЙН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоонд гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс хасах, гишүүн байгууллага болон иргэний эрх, үүрэг, хүлээх хариуцлага зэргийг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Гишүүн элсүүлэх

2.1. Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбооны дүрмийг хүлээн зөвшөөрсөн иргэн, байгууллага уг холбооны гишүүн болох хүсэлт гаргаж гишүүнээр элсэнэ. Гишүүнээр элсэх иргэн хавсралт 1-д заагдсан анкетийг, байгууллага хавсралт 2-д заагдсан тодорхойлолтыг тус тус бөглөнө.

Гурав. Гишүүний эрх, үүрэг

- 3.1 Холбооны дүрмэнд заагдсан бүрэн эрхийг эдэлнэ.
- 3.2 Гишүүнийг баталсан үнэмлэх олгож гишүүнээр бүртгэнэ.
- 3.3 Холбооны зүгээс зохион байгуулдаг аливаа арга хэмжээнд оролцох
- 3.4 Холбооноос зохион байгуулж байгаа дотоод ба гадаадын хурал, семинар, лекц, зөвлөгөөн, үзэсгэлэн, хэлэлцүүлэгт хөнгөлөлттэй нөхцлөөр оролцох эрхтэй.
- 3.5 Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг үнэ төлбөргүй хурдан шуурхай авах эрхтэй.
- 3.6 Холбоогоор уламжлуулан шагнал, урамшуулалд тодорхойлогдох эрхтэй.
- 3.7 Мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, зэрэг дэв олгох сургалтанд хамрагдах эрхтэй.
- 3.8 Холбоогоор зуучлуулан хөнгөлттэй нөхцлөөр байгууллагын гишүүдийг гадаадын сургууль, курст мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах
- 3.9 Бизнес эрхлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлээ шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа авах
- 3.10 Холбооны зүгээс зохион байгуулдаг аливаа арга хэмжээнд оролцох мэдээллээр хангагдах, урилга хүлээн авах эрхтэй.
- 3.11 Холбооны веб сайтад өөрийн байгууллага компаний эмблем, рекламьг байршуулах.
- 3.12 Холбооны зүгээс тавигдах бизнес санал, хамтран ажиллах саналыг хүлээн авах боломжтой.
- 3.13 Холбоогоор дамжуулан Байгууллага хамт олноороо Төр засгийн шагналд тодорхойлуулах

- 3.14 Холбоогоор дамжуулан олон улсын Бизнес яармаг, үзэсгэлэнд, аялалд оролцох
- 3.15 Татварыг хэсэгчлэн төлж болно.
- 3.16 Холбооны үйл ажиллагаатай холбоотой санал шүүмжлэлийг веб сайтаар дамжуулан чөлөөтэй өрнүүлэх
- 3.17 Холбооны дэргэдэх 1.Стратеги, бодлого төлөвлөлт 2.Гадаад харилцаа 3.Олон нийт, дотоод үйл ажиллагааны зөвлөлүүдэд гишүүнээр элсэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах
- 3.18 Холбооны вэбсайтад байршдаг гишүүдийн жагсаалтанд өөрийн компаний нэрийг оруулах
- 3.19 Холбоотой хамтран мөн холбооны туслалцаа дэмжлэгийн үндсэн дээр төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах
- 3.20 Өөрийн аж ахуйн нэгжийнхээ ажиллах туршлагийг сонирхож буй талдаа холбоогоор дамжуулан сурталчлуулах
- 3.21 Холбооны жинхэнэ гишүүн гэсэн логог өөрийн вебсайт болон албан бланкан дээр байрлуулах
- 3.22 Холбооны дүрмэнд заагдсан бүрэн үүргийг хүлээнэ.
- 3.23 Холбооны гишүүн иргэн, байгууллага нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг явуулахдаа ажлын үнийг холбооны гишүүд болон удирдах зөвлөлөөс гишүүдийн нийтээр дагаж мөрдөхөөр баталсан тухайн ажилд харгалзах үнийн хамгийн бага хязгаараас буулгахгүй байх.
- 3.24 Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахдаа батлагдсан стандарт, техникийн заавар, норм норматив, жишиг үнийг мөрдөхөөс гадна гүйцэтгэж байгаа ажлын чанарт онцгой анхаарал хандуулж ажиллана.
- 3.25 Гишүүн иргэн, байгууллага нь гишүүний татвараа тогтоосон хугацаанд төлнө.
- 3.26 Холбооны нэр хүндэд нөлөөлөх аливаа хэлцэл маргаанд оролцохгүй байх, МУ-ын хуулийн хүрээнд ажиллах.
- 3.27 Холбооны нэр хүндийг өндөрт өргөж ажлын гологдол гаргахгүй ажиллах үүрэгтэй.
- 3.28 Шинэчлэн батлагдсан норм үнэлгээг мөрдөж ажиллана.

Дөрөв. Гишүүнчлэлийн татвар, хураамж

- 4.1 Иргэн, байгууллага нь Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоонд гишүүнээр элсэхдээ элсэлтийн хураамж төлөхгүй.
- 4.2 Гишүүн иргэн нь жилийн татварын хураамж 50000 төгрөг төлнө. Татварыг жил бүрийн II улиралд багтаан төлнө.
- 4.3 Гишүүн байгууллага нь уг холбоонд элссэн өөрийн байгууллагад ажиллаж байгаа гишүүн бүрийн тоогоор 50000 төгрөгийн татварыг жилд нэг удаа төлнө. /өөрөөр хэлбэл тухайн байгууллагын 5 хүн гишүүнээр элссэн бол гишүүн тус бүрийн 50000 , байгууллагын 250000 нийтдээ **500000** төгрөг гэх мэт/. Жилийн татварыг тухайн жилийн II улиралд багтаан төлнө.

Тав. Гишүүний хүлээх хариуцлага

5.1 Холбооны гишүүн иргэн, байгууллага нь энэхүү журмын 3.23 дахь заалтыг зөрчсөн нь нотлогдсон бол эхний удаа холбооны удирдах зөвлөлөөс анхааруулга өгөх ба зөрчлийг давтан гаргасан бол холбооны гишүүнээс хасах арга хэмжээг авна.

5.2 Холбооны гишүүн иргэн, байгууллага нь энэхүү журмын 3.24 дахь заалтыг зөрчиж, энэ талаар үйлчлүүлэгчдээс холбоонд гомдол ирсэн тохиолдолд удирдах зөвлөлөөс эхний удаа зөрчлийг арилгаж, дахин зөрчил гаргахгүй байх талаар анхааруулга өгнө. Хэрэв зөрчлийг давтан гаргасан бол тухайн зөрчил гаргасан иргэн, байгууллагыг холбооноос зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох, гишүүний холбооноос үр шим хүртэхэд нь хязгаарлалт хийнэ. Зөрчлийг удаа дараа гаргаж, удирдах зөвлөлийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбооны гишүүнээс хасах хүртэл арга хэмжээг авна.

Зургаа. Гишүүнээс хасах

6.1 Гишүүн иргэнийг татвараа тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд сануулга өгөөд 2 сар өнгөрвөл гишүүнчлэлээс хасна.

6.2 Гишүүн байгууллагыг татвараа сануулга өгснөөс хойш 2 улиралд багтаан төлөөгүй тохиолдолд гишүүн байгууллагаас хасна.

6.3 Энэ журмын 3.23, 3.24-т заасныг удаа дараа зөрчсөн иргэн, байгууллагыг холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр гишүүнээс хасна.

ГЗЗФХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНКЕТ

1. Ургийн овог:.....Овог:..... 2. Нэр:.....
 3. Төрсөн огноо 4. Хүйс: 5. Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг

 6. Одоогийн харъяалал:
 7. Регистр: 8. Боловсрол.....9. Мэргэжил:
 10. Мэргэжлийн зэрэг, дэв
 11. Одоо болон урд ажиллаж байсан газар:

N	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
---	------------------	---------	---------------

1.
2.
3.
4.

12. Төгссөн сургууль, курс

N	Төгссөн сургууль	Хэдэн онд	Мэргэжил, цол
---	------------------	-----------	---------------

1.
2.
3.
4.
5.

13. Гавъяа шагнал

N	Шагналын нэр	Хэдэн онд
---	--------------	-----------

1.
2.
3.
4.
5.

Холбоо барих утас:

Email:

Гарын үсэг, нэр...../...../

2012.он сар..... өдөр

Хавсралт 2

Гишүүн байгууллагын тодорхойлолт

№	Компаний нэр	Захирлын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Гишүүдийн тоо	Байршил	Утас	Факс	Вэбсайт	Майл хаяг